

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

XXXVII (392)

2013

(200-212)

МОНГОЛ УЛСААС ЭХ ОРОНДОО ХАРЬЖ ИРСЭН УЙГАРЧУУД

Абдурахман Айбай *

Уйгар үндэстэн болбол аль эртнээс Монголын өндөрлөгт амьдран сууж байсан үндэстний нэг болно. Нийтийн он тооллын IX зууны үед Орхон, Енисей голын орчмоор амьдарч байсан Уйгар аймгийн гол хэсэг нь Монголын өндөрлөгөөс баруун өмнө /одоогийн Шинжан/ дэх эх нутагтаа нүүж ирсний хойно, ард нь хоцорсон Уйгарчууд анхандаа Монголын өндөрлөг дэх Сирвэй аймаг, хойно нь Монголчуудын хэрэйд аймаг ба түрэг хэлээр ярьдаг найман, мэргэд аймагтай нийлж, зарим нь Монголд ижилсэн хайлсан байжээ. Нийтийн он тооллын XIII зууны үед, Чингис хаан монголын тал нутгийг нэгтгэн нэгдэлтэй Монгол улсыг байгуулж, түүний хойчис 1279 оноос 1368 оны хооронд дэлхийд нэр алдаршсан их улс болох Юань улсыг байгуулав. 1911 онд Монголын хаан Цагаан хааны дэмжилгээр “өөртөө засах” улс болсныг зарлажээ. Хожим нь Монгол улсын ардын хувьсгал ялж, 1921 оны 3 сарын 11-ний өдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улс байгуулагдаж, 1945 оны 2-р сарын Англи, Америк, Зөвлөлт Холбоот Улсуудын тэргүүн нарын Ялтад болсон хурал дээр Зөвлөлт Холбоот Улс Японыг эсэргүүцэх дайнд оролцох урьтал нөхцөлөөр Монгол улсын тусгаар тогтнолыг мэдрэв. 1946 оны 1 сарын 5-ны өдөр Дундад улсаас тусгаар тогтносон Монгол улс гэдгийг хүлээн танив. Монгол улс болбол 156.65 түмэн тэгш дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, 314 түмэн /2009 оны хүн амын бүртгэл/ хүн амтай. Түүхийн улирлаар мянган жилийн дараа, мөн ч XIX зууны эцсээр Атуш, Кашгар, Хотайны наймаачин уйгарчууд Алтайгаар халх монголын тал нутагт дахин орж, арилжаа наймаа хийж эхлэв. Цагаан сэтгэлтэй Монголчууд уйгар наймаачныг өөрийн ах дүү төрөл садантайгаа адил халуунаар хүлээн авч, засгийн талаас ч тэдэнд монголтой адил эрх тэгш амьдрах эрх өгч харгалзав.

* Уйгар үндэстэн. 1953 оны 3 дугаар сарын 5-нд төржээ. 1955 онд аав ээжээ дагуулан Монгол улсаас эх орондоо буцаж иржээ. Их сургуулийн жинхэнэ ангиас төгссөн. Дундад улсын эв хамт намын гишүүн, одоо Шинжаны ардын хэвлэлийн хорооны дарга. Дундад улсын хэвлэлийн эрхийн нийгэмлэгийн хэрэг эрхлэгч, Дундад улсын үндэстний хэвлэлийн эрхийн нийгэмлэгийн дэд дарга, Шинжаны ном тараах нийгэмлэгийн байнгын дэд дарга, Шинжаны зохиолчдын нийгэмлэгийн хэрэг эрхлэгчийн тушаалыг эрхэлж байна. Абдурахман Айбай нөхөр хэвлэлийн ажилд оролцсон 33 жилийн дотор 1989 онд төрийн явдлын хорооноос олгосон “Бүх улсын улсдаа буцсан дундадын харьяат гэр бүлийн шилдэг сэхээтэн” гэдэг хүндэт цол, 1995 онд өөртөө засах орны намын хороо, ардын засгийн ордны “дөрөвдүгээр хугацааны дундад улсын ном сэтгүүл тараасан шагнал”, 2008 онд “Дундад улсын хэвлэлийн алдар хүндийн медаль”, 2011 онд “Дундад улсын хэвлэлийн засгийн ордны шагнал” зэрэг аль олон алдар хөхүүлэл хүртжээ.

Монгол улсад хамгийн анх удаа одсон уйгар наймаачин бол Хемразан, Сэлэвэй, Осор, Ажим нар болно. Тэд сахар, чихэр, цай, зүү утас, хувцас хунар, эм мэтээр наймаа худалдаа хийдэг байсан байна. Тэр үед Ховдод жанжин сууж, Халх Монголын нэг хэсэг нь Дундад улсын харьяанд байсан болохоор хоорондоо явалцах асуудал дээр ямар ч гарын гүйцэтгэл хийдэггүй байсан юм. Тэдгээр наймаачин авч очсон бараагаа монгол малчдын үнэгний арьс, булганы арьс, заар, ороонгын эвэр мэтээр сольж ирээд, Алтайд сууж байсан дотор газраас ирсэн хэдэн наймаачинд дээр үнээр худалдаж өгөөд, хэдэн арав дахин ашиг олдог байсан билээ. Тус газрын засгийн талаас: “энэ наймаа бол нууц далдуур хийсэн наймаа” гэж заримдаа албадан хурааж авдаг байв.

XX зууны 20 онд Шинжан нэг хугацаа тайван тогтуун болж, ард түмний амьдрал ч дэгжрэн сайжирч, Хотайны Энэтхэг, Пакистан /тэр үед тусгаар тогтноогүй/-ы хилийн наймаа, хязгаарт урдах Зөвлөлт Холбоот Улстай хилийн арилжаа наймаа хийж, Или, Тарвагатай болон Ташкент, Алма-Ата-гийн хоорондох арилжаа наймаа ч хөөр хөгжөөнтэй явагдаж, тэр үед Алтай газар оронд Монголтой хийсэн арилжаа наймаа ч хөөр хөгжөөнтэй болж Атөш, Кашгар, Хотайнаас Алтайд ирээд арвин олон наймаачид Монгол улсад арвин их бараа гаталгаж, бас зарим нь суурьшин байршсан байжээ. XX зууны хориод оноос хойш Шинжанд дайн дажин ихдэж, үймээн самуун улирсан учраас ард түмэн амьдрахын аргагүй болж, Хамил, Турфан, Читай, Алтай мэт газар орон дахь нэг хэсэг уйгар залуучууд засгийн газрын цэрэгт баригдахаас айж, аж төрж амьдрахын төлөө Хамил, Жимсайр, Алтай мэтийн хилээр хэсэг хэсгээр Монгол улсад зулж оров. Халх монголчууд эдгээр зулж орсон хүмүүсийг цагаачаар үзэж, тэднийг Ховд, Баян-Өлгий мэт аймагт байршуулжээ.

Эцгийн минь эцэг, миний элэнц Супахун гэдэг хүн Атушийн Азахагийн хүн бөгөөд хэдэн үеэрээ хошуучин байсан байжээ. 1820 оны орчмоор Атушийн Азахагийн арвин олон хүмүүс атар хагалбарлан мал малжихын төлөө, одоогийн Катавилан /заг тоорой ургасан маш сайн тариалангийн газар/-д нүүж ирэхэд минь элэнц эцэг Супахун ч нутагтай хамт нүүж ирээд хошуучийн амьдралаа хийж, миний өвөг эцэг ч нэг насаараа хошууч болж амьдралаа өнгөрүүлсэн юм. Миний эцэг Айбайдулла 1914 онд 18 настайдаа Катавиланаас гарч наймаачидтай хамт Өрөмчид ирээд, урьдаар Хар-усун, Тарвагатай болон урдах Зөвлөлт Холбоотын харьяан дахь Ташкент, Семей мэтийн балгасанд наймаа хийжээ. 1924 онд Алтайд ирж, Монгол улсын Ховд хот болон Алтай хотын хооронд амьдралд хэрэгтэй сахар, чихэр бараа худалдах наймаа хийж, 1928 онд Монгол улсын Завхан хотод бүх халхаар анх удаа гуа тарьсан билээ. Миний эцгийн жинхэнэ нэр нь Айбайдулла Митили гэдэг. Гэтэл Монгол улс дахь хасагчууд дотночилон “Айбайлам” гэж дуудсаар байгаад Айбайлам нэртэй болсон юм. Гэтэл Монголчууд улам ч дөхөмчлөөд Айбай гэдэг нэр өгчээ. Одоо энэхүү “Айбай” гэдэг нэрээр би, миний хөвгүүн болон хойч үе ч овог болгов. Миний ээжийн эцэг Юсүп Эхүн Яков гэдэг. Хэрээд тоосго үйлдвэрлэдэг хүн байсан. Тэр 1918 онд Алтайд одож, гэр барилгын ажил хийж яваад Алтайд гэрлэсэн санж. 1937 онд цагаан Оросчууд Алтайд хасаг, уйгар, хятадыг булаан дээрэмдээд алж хядаад үймүүлсэнд, миний нагац аав ээж хоёр 13 настай миний ээжийг аваад ууланд гарахаар зулж яваад, миний нагац ээжид сум тусч нас нөгчин, миний нагац аав Юсүп Эхүн минь ээжийг дагуулаад Монгол улсад зулан оржээ. 1937 онд миний аав ээж хоёр Ховдод хурим хийж, хүүхэд шуухадтай болж суурьшин суужээ.

XX зууны 30-аад оны эцсээр Монголын Ховд, Өлгий, Завхан, Улаанбаатар, Орхон мэт хотуудад бүлэг бүлэг уйгар айл байршиж, Уйгарчуудын зах дэлгүүр буй болж, зах

хөдөөгөөс хотод ирсэн малчин Монголчууд Уйгарчуудын хийсэн полоов, хуушуур, бууз банш, татсан будаа мэтийг маш амтархан идэж, харихдаа ч эхнэр ба хүүхэд шуухаддаа өгөхөөр уутлаад авч харьдаг байсан билээ. Тус зах дэлгүүрт бас төмрийн дархан, үүсч, хувцас оёх газар, морь тахлах газар, морин тээрэм, модчин мэт дэлгүүр хойно хойноосоо ундрэн гарсан юм. Ахасу-ийн Бекир Молла 1930 оны эхинээр Өлгий хотын дунд сургуулийн амьдралын хэрэгт хариуцлагатай болж байхдаа голын хажуудах тэгш газарт бух [суваг] малтан ус гаргаж, улс даяарт анх удаа шар лууван, төмс, төвд хаш, бөөрөнхий цагаан ногоо зэргийг тарьж, энэ сургуулийн 300 өнгөрөх багш сурагчийн идэх ногооны асуудлыг шийдвэрлэж өгсөн бөгөөд бас Өлгий хотод нэг лалын сүм байгуулжээ. Бекир Молла 1940 онд Ховд хотод нүүж ирээд том нэг хоолны газар гаргаж, хийсэн полоов, хуушуур, бууз банш, татсан будаа нь Монгол улсад нэр алдаршиж, монголчууд булаалдан иддэг билээ. 1980 онд Монгол улсад засгийн газраас Өлгий хотын түүхийг бичихдээ Бекир Молланы нэрийг онцгойлон бичиж оруулсан байжээ.

Тэр жилүүдэд Ховд, Өлгий хотуудад урдах Зөвлөлт Холбоот улсын засаг захиргаанаас тус газарт байгуулсан тоосго, шавар, бугаш байшингаас өөр барилга бараг үгүй гэлтэй билээ. Учир нь монголчууд жилийн дөрвөн улиралд эсгий гэрт байж дассан болохоор байшин гэр маш цөөхөн байсан. Гэтэл уйгарчууд өөрийн суух гэр барьж, дараа нь наймаа хийх дэлгүүрээ тоосгоор барьж, гэр байшин барих үйлсийг хөөр хөгжөөнтэй болгосон билээ. Уйгар дархчууд байсаар байж засгийн газрын албан гэрийн давхар байшин гэрийг дааж аваад барьдаг болсон байна. Кашкарын Өмир дэфүт гэдэг хүн Өлгий хотод тоосгоны үйлдвэр гаргаж, бүх хотын барилгын ажлыг дааж аваад барьсан билээ. Ховд хотын одоогийн зээл гудамжинд байх том цагаан улиасыг Абдурахман Савут тэндхийн уйгарчуудыг зохион зохион байгуулж тарьсан юм. Далан жилээс нааш эдгээр цагаан улиас өсөн сахлагжиж, Ховд хотын чимэг болсон байна. Одоогийн Ховд хотын засгийн газрын албан гэрийн барилгыг тухайн үед Турфаны Лохцоны Яков гэдэг барилгачин барьсан юм.

Тэр жилүүдэд Монголчууд дан ганц мал аж ахуйгаар гол болгосон малчин хүмүүс байсан болохоор зөвхөн бага сага арвай, сулиас өөр тарьмал тарьдаггүй билээ.

Шинжанаас одсон Уйгарчууд болбол тариачин хүмүүс болохоор өн шимлэг ус элбэг, уужим тал нутагт санаан тааваараа тарьмал тарих аж амьдралаа эхэлсэн юм. Анхны жилүүдэд Монголчууд нэг хониороо нэг гуа сольж авдаг явдал ч байсан. Үргэлж тариа будаагаар хомсдож байсан энэ улсад нэг л доор хэдэн мянган му тарианы газар гаргасныг үзсэн Монголын засгийн газар ч тариачин Уйгарчуудад маш талархаж, тэдний их хэмжээгээр атар хагалбарлан тарьмал тарихыг зөвшөөрсөн бөгөөд тэднийг тариалангийн гаалиас хэлтрүүлжээ. Хойнох жилүүдэд тариачдад тэтгэмжийн мөнгө өгөхийн хамт тарималын хураалтын үед цэрэг гарган тариачдыг хавсран тариа будааг нь хураалцаж өгдөг билээ. Тэр үед Монгол улсад хэдэн мянган му газарт тарьмал тарьдаг. Хэдэн мянган хоньтой, хэдэн зуун тэмээ, морь, үхэртэй уйгар баячууд ундрэн гарав. Пицан хошууны Цохутам кризигээс одсон баян Сафут /хоч нэр нь Тотур/ гэдэг хүн 1937 онд 3000 хонь, 200 адуу, 200 саалийн үхэр, 60 тэмээ болон тариа, арвай тарьдаг 1500 му тарианы газартай байсан билээ. Үүнээс гацаа Ибирией баян, Юсүп Эхүн баян, Айбайлам /миний эцэг/ Яков төмөрчин, Түниези баян, Ошур Эхүн баян, Хар гирем, Дурти Эхүн, Тийф Эхүн мэтийн хүмүүс Монгол улсад нэртэй баячууд болсон билээ. Миний эцэг Айбайлам Ховд хотын Намин гэдэг газарт 300 му тарихын газар гаргаж, түүндээ тариа, арвай, гуа тарьдаг юм. Миний эцгийн тарьсан гуа бүх Монгол

улсад алдартай болохоор жил бүр нийслэл хот Улаанбаатарт хэдэн арван машин гуа тээвэрлэн хүргэдэг. Үүнээс манай гацаанд 500 өнгөрүү хонь, 100 өнгөрүү адуу, 100 өнгөрүү үхэр, 40 тэмээ байсан юм. Би 1953 оны 3-р сарын 5-ны өдрийн өглөө Ховд хотоос найман километр зайтай байх тариалангийн газар болох Наминд отгон хөвгүүн болж төрсөн билээ. Одоо Алтай аймгийн Цэнгэл шианд байх Хенип Алим Эхүны ээж нь Бүрисха болбол миний газар ээж болно. Миний эцэг гурван охины дараа нь нэг хөвгүүн төрсөн, орой хонь алж, айл хошоо хүмүүс ба хол ойрхи нөхөр нараа дуудаж хөвгүүн гарсан баяр хийх болж тогтоод, үдийн хойно хоёр хонь алж хайсанд чанаж байтал сумын засгийн газраас бачим мэдэгдэл ирж, тэр өдрийн өглөө Зөвлөлт Холбоот улсын тэргүүлэгч Сталин таалал болсон тул, бүх Монгол улсын ард түмэн гучин өдөр гашуудал мэдүүлж, энэ гучин өдөр дотор хэн ч гэсэн баяр найр хийж болохгүй, ямар нэг хүн баяр найр хийдэг болбол ял тулган шийтгэнэ гэж зарласан ажээ. Ингээд миний эцэг надад хийх болсон найраа хойшлуулаад нэгэн сарын дараа хийжээ.

1938 оноос эхлээд Зөвлөлт Холбоот Улсад явагдаж байсан “цэвэрлэн арилгах” хөдөлгөөн Монгол улсад ч явагдаж, улсын доторх алдар нэртэй сэхээтэн, лам хувраг, баячуудыг баривчилж шоронд хорьж, тэдний эв хамт ёсыг эсэргүүцсэн, гадаадтай хэлхэлдсэн гэдэг хар хор наажээ. Тэдгээр баривчлагдсан хүн хүнд хэцүү эрүү цаазын тамлалд учирч төгссөн билээ. Бүх улс даяар таван түмэн хүн хорлогдож, түүний дотор уйгар сэхээтэн, уйгар баячууд ба нутгийн нэр хүндтэй хүмүүсээс мянга өнгөрүү хүн байсан юм. Пицан шианы Чихатимийн Сафут Хэмүй гэдэг хүн Монгол улс дахь тэргүүн баян байсан. 1938 онд цэвэрлэн арилгах хөдөлгөөн эхэлсэн үед айгаад гэр дэх 20 килограмм алт, мөнгө, зоосоо эсгийгээр ороогоод хөрстэй газар талд нь давс түрхэж, авдраа хялгасан аргамжаар баглаад, гэрийн ардах уулын хормойд авч одоод болохоор замд гарсанд түүний есөн настай хөвгүүн нь Абдурахман тэднийг дагаж уулын хормойд ойртоод ирэхэд, эцэг нь үзээд булдаг болсон газраа мэдүүлэхгүйн төлөө хөвгүүнээ хараагаад хөөж явуулжээ. Тэд алтаа уулын ард булсны гурван өдрийн дараа орой нь цагдаа ирж ах дүү хоёрыг барьж аваад явснаар тэр ах дүү хоёр дахиж харьж ирсэнгүй. Хэдэн жилийн дараа эмэгтэй нь Айхан хөвгүүн Абдурахмантай хоёулаа тэр алт булсан газрыг хэдэн сар хайгаад, газар болгоныг малтсан боловч олж чадсангүй. Тэр удаагийн “цэвэрлэн арилгах” хөдөлгөөн Монгол улсад шинэхэн өрнөн хөгжиж байсан Уйгарын утга соёлыг маш их хохиролд учруулж бүрмөсөн үгүй болгосон юм.

Тухайн үед Монгол улсад одсон Уйгарчуудын олонх нь бага залуучууд болохоор ураглах асуудал болбол маш хүчиртэй явдал болж байсан билээ. Шинжанаас гэр бүлтэйгээ одсон уйгарчууд өөр хоорондоо худ, худгай болсон бөгөөд, бас арвин олон залуучууд хасаг охинтой хуримлаж, бас зарим нь монгол охинтой ураг холбосон байв. ХХ зууны 40-өөд он болоход Монгол улсад шинэ нэг үеийн уйгар залуучууд өсөн бойжжээ. Гэтэл Монгол улсад байсан уйгарчуудад тулгарч байсан бас нэг хүчиртэй асуудал болбол уйгар хэлний сургуульгүйнх билээ. Хэрээгээс ирсэн тоосго шатаах Юсүп Эхүн Яков гэдэг хүн /миний ээжийн эцэг/ 1940 онд тусгайлан хөх тоосго шатааж боловсруулаад Ховд хотын төвд зургаан тасалгаатай нэг уйгар хэлний сургууль байгуулж, энэ сургууль нь одоо засгийн талаас соёлын өв болгон хамгаалж байна. Гэтэл энэ сургууль байгуулагдаад бүтсэн боловч уйгар хөвгүүдийг сургуульд авсангүй, учир нь уйгар багш олдсонгүй, нэг хоёр соёлтой хүн олдсон боловч нөхцөл хүрэлцсэнгүй, түүний хамт уйгар хичээлийн ном бас үгүй билээ. Эцэстээ энэ сургууль уйгар сургуулийн нэрийг хадгалж хоцорсон боловч уйгар хөвгүүд монгол хэлээр суралцах болсон юм. Хожмын жилүүдэд манай гэрийн нэг харамсалтай хэрэг болбол миний их

эгч Дурдихан Монгол улсад монгол хэлээр сургууль уншив. Хоёрдугаар эгч минь Рейхан Атушт уйгар хуучин үсгээр сургууль уншив. Бага эгч минь Зүрэй Борталд шинэ уйгар хуучин үсгээр сургууль уншив. Гэтэл гурван эгч минь соёлтой байсан ч, нэг нэгнийхээ захидлыг уншиж чаддаггүй байв.

XX зууны 40-өөд онд Монгол улсад хамтрал байгуулах нийгэм журамт хөдөлгөөн маш хөөр хөгжөөнтэй явагдаж, тэнд байсан уйгарчууд ч энэ хөдөлгөөнд маш их халуурхагаар оролцож, Хэйит Эхүн Рузи Монгол улсын Өлгий аймгийн Ахачи гэдэг хамтралын дарга болж, энэ хамтралыг маш ахар хугацаан дотор жишээч хамтрал болгон байгуулж, 1952 онд Монгол улсын хөдөлмөрийн гавшгайчаар шагнагджээ. Атушийн Хэнзэй Эхүн гэдэг хүн олон жил Хэйит Эхүний газар доор дэд дарга болж, хамтралын эдийн засгийг хамаарчээ. Атушийн хар Гирем гэдэг хүн Ховд хотын нэг хамтралд олон жил дэд дарга болж ажилласан бөгөөд Монгол улс дахь уйгарчуудын майшираф бүжгийг зохион байгуулж, гараг бүр нэг удаа дэв дүтгаар утгаар цохиж, майшираф бүжиг бүжиглэж, үүнд монголчууд ч ирж оролцоод бүжиг бүжиглэдэг байсан юм. Түп Эхүн гэдэг хүн Буян сумны уйгар 16 дугаар хамтралын дарга болсон юм. Монгол улсад байсан арвин олон уйгар залуучууд цэрэгт орж цэргийн алба хаажээ. Ховд, Өлгий мэт хотод ч арвин олон уйгар залуучууд засгийн ордонд ажил хийж байв. Читайгаас одсон Яасай гэдэг хүн эмэгтэй нь Халитмтай хоёулаа Ховд аймгийн уран сайхны бүлгэмд дуучин, бүжигчнээр орж, хожим нь Яасай Ховд аймгийн уран сайхны бүлгэмийн дарга болж, 1962 онд “Монгол улсын ардын жүжигчин” гэдэг маш дээд алдар цол олжээ.

Монгол улс Дундад улстай ямагт нөхөрсөг сайхан өнгөрсөөр ирж, Дундад улс Японыг эсэргүүцэх дайнд баатарлагаар нас барсан баатар байлдагчдын алдар нэрийг хадгалж хоцрохын төлөө Улаанбаатар хотод дурсгалын хөшөө чулуу босгож баатарчуудын нэрийг сийлэн бичсэн юм.

1939 онд хоёрдугаар удаагийн дэлхийн дайн үүсч, 1941 оны 7 сарын 22-ны өдөр Гитлерийн Германаас Зөвлөлт холбоот улсад түрэмгийлэл хийсэнд, Монгол улс Зөвлөлт холбоот улсад маш арвин эд бараагаар дэмжлэг өгч, хойно нь дайны өмнө фронтод хэдэн түмэн сайн дурын туслах цэрэг явуулсан билээ. Энэхүү сайн дурын туслах цэрэг дотор уйгар цэрэг ч байсан юм. Тэдний олонх нь дайнд нас баржээ. Ярхины Исмэйл Турсун гэдэг уйгар залуу дайнд эрэлхэгээр байлдаж, нэгдүгээр зэргийн гавьяа байгуулж цэргийн хурандаа дарга болжээ. Турфаны Айтингүл Сайсанов гэдэг хүн 1939 онд Монгол улсын агаарын цэрэгт оролцоод нисгэлийн жолооч болж, монгол жолоочид түүний нэрийг зөв дуудаж чадалгүй Зайсанов гэдэг болсон байжээ. Хоёрдугаар удаагийн дэлхийн их дайн эхэлсний дараа Монгол улсын засгийн газар Зөвлөлт холбоот улсыг дэмжиж өмнө фронтод хэдэн дайны нисгэл явуулж, Зайсанжав тэрхүү байлдааны нисгэлийн жолоочийн нэг нь байсан билээ. Тэр Ленинградын нэг удаагийн дайнд фашистын маш чухал нэг бэхлэлтийг дэлбэчиж, улаан цэрэгт урагшлах зам нээн өгч гавьяа байгуулаад алтан медалиар шагнагджээ. Дайн төгссөний хойно Монгол улсын засгийн газар тэдгээр дайнд оролцсон залуучуудыг Улаанбаатар, Москва мэт газарт сургуульд явуулж, онцгойлон хүмүүжүүлээд засгийн ордны чухал газарт ажиллуулжээ. Исмэйл дарга болбол Монгол улсын гадаад явдлын яамны албан гэрийн дарга болж байсан. Тэр 1947 онд машины эндэгдэл гарч Улаанбаатарт нас нөгчжээ. Зайсанов 1950 онд Ховд хотод уушгийн сүрьеэ өвчнөөр нас баржээ.

Турсун дарга дайны дараа Улаанбаатар хотын амар төвшнийг хамгаалах байгууллагын дэд даргаар удаан жил ажилласан байв. Ахасугийн Хэсэн Эхүн гэдэг уйгар жолооч өмнө фронтоос шархтан нарыг зөөж яваад шархадсан боловч эрэлхэг

баатарлагаар машинаа жолоодож, шархтаныг аварч гараад, Монгол улсын “тэргүүн зэргийн гавьяатан” гэдэг медиалаар шагнагджээ. Дэлхийн хоёрдугаар удаагийн дайны үед Монгол улс дахь уйгарчууд засгийн ордонд өргөдөл өргөж эрийн домогт хүрсэн хөвгүүдээ дайны өмнө фронтод явуулж, өрх бүр эд мөнгө гаргаж, засгийн газарт өгч, фашистыг эсэргүүцэх дайнд өөрийн хувь нэмрээ өргөсөн юм.

Хоёрдугаар удаагийн дэлхийн дайны дараа Монгол улсад аж ахуй үтэр түргэн хөгжиж, хамтралжих хөтөлбөр ч маш түргэджээ. Уйгарчууд Монгол улсын засгийн газрын уриалгыг идэвхтэй дэмжиж, нийгэм журамт бүтээн байгуулалтад халуурхагаар оролцжээ. Монголчуудын төв голч асвар цагаавар энэрэнгүй сайхан сэтгэл нь тэдгээр цагаачин уйгарчуудын сэтгэлд үүрд мартагдашгүй гүн нөлөө үлдээсэн билээ. Би бага балчир цагаасаа эхлэн Монгол улсаас эх орондоо харьж ирсэн ахмад хүмүүсийн амнаас үүний тухай маш арвин үлгэрийг сонссон билээ. Тиймээс тэр үлгэрүүдээс хоёрыг л ярьж алив бүхэнд жишээ болгоё. Читайн Төмөр Ниязи гэдэг хүн 1926 онд Монгол улсад одсон санжээ. Тэр хүн асвар цагаавар, баясангуй, учир явдлыг сайн мэддэг, гарын элдэв зүйлийн эрдэмтэй сайн наймаачин байжээ. Тэр Ховд хотод наймаа хийгээд дэмий удалгүй арвин олон монголчуудтай танилдаад ах дүү мэт болсон билээ. Ховд хот болбол хил хязгаарын хот болохоор мянга өнгөрүү цэрэг сууж байв. Төмөр Ниязи энэ цэргийн гурван цагийн хоол будааг нь дааж авсан болохоор гар доорх хүмүүс нь өдөр бүр хэдэн бүлэг боорцог болгож, хэдэн арван хайсан хот будаа хийж, өвлийн түлээ түлшийг нь бэлтгэх чухалтай байв. Тэр үеийн засаг гэр барилгын бугашийг Зөвлөлтөөс машинаар зөөж авчирдаг тул Төмөр Ниязи бугаш шатаах нэг том үйлдвэр гаргаж, 10 түмээс өнгөрөх бугаш боловсруулж, цэргийн тойрогт хэвтэх байр, албан гэр байгуулж өгчээ. Ингээд тэр Ховд хотод нэртэй хүн болсон байв. Монгол улсын засгийн газар Монголын хилээр орж ирсэн уйгарчуудаас юуны түрүүнд: “гартаа ямар эрдэмтэй вэ чи?” гэж асуудаг. Хэрэв: “төмрийн дархан, модчин, хувцас оёх мэт эрдэмтэй би” гэвэл өөрийн наймаагаа хий гэдэг. Хэрэв: “гартаа эрдэмгүй” гэвэл “төмөр Ниязийн тэнд од” гэж түүнийг явуулдаг. 1930 онд Төмөр Ниязын гарт ногоо тарьдаг, түлээ түлш зөөдөг, чулуун бугаш шатаадаг, барилга барьдаг, хот будаа хийдэг будагчин мэт 300 шахуу ядуу өнчин уйгар залуучууд ажиллаж байв. Тэдгээр жилүүдэд Төмөр Ниязи аймагт байхдаа нэг гоё сайхан монгол охинтой танилцаад хоорондоо янаг сэтгэлтэй болж, ингээд тэд хурим хийх болоход монгол охины аав ээж нь: “энэ уйгар манай охиныг мусульман болгочихно, болохгүй” гэж огт зөвшөөрсөнгүй болохоор, энэ булаалдаан хоёр гурван сар үргэлжилжээ. Ингээд Төмөр Ниязи аргагүй болохдоо Ховд хотын даргыг хайж одоод байдлаа хэлж мэдүүлээд, тэдний хавсрахыг гуйчилжээ. Одоох хотын дарга охины аав ээжийг нь дуудуулж ирээд: “Бид бүгдийг нэг тэнгэртэй болгосон юм. Манай өвөг дээдэс Чингис хаан ч ганц охиноо Идугуд уйгар хааны барцаг Артатигинд өгч, түүнийг өөрийн тавдугаар хөвгүүнээ болгож авсан билээ. Төмөр Ниязи мэт цагаан сэтгэлтэй, гартаа эрдэмтэй, сэргэлэн ухаантай уйгар залууд охиноо өгөхгүй яах вэ чи. Охиныхоо зол жаргалд саад бололгүй өнөөдөр хуримыг нь хийж өг” гэжээ. Тэд хоёр хурим хийгээд Төмөр Ниязи монгол охинд Мариямахан гэдэг уйгар нэр тавьж, уйгар хэл сургажээ. Тэд таван хөвгүүнтэй болж, насан турш маш янаг дотно зол жаргалтай амьдарч, Монгол улс даяарт нэр нүүртэй хүн болсон билээ.

1936 оны 6-р сард хамтралын дарга Хейит Эхүн Рүзи хэдэн ажилтнаа дагуулж Ховдоос Улаангом хотод одож, монголчуудаас 300 морь худалдаж аваад, адуугаа туугаад харих замд гарчээ. Тэд явсаар нэг нуурын хөвөөнд ирэхэд Хейит Эхүн Рүзи өвчлөөд нэг халаад, нэг чичрээд, бүх бие нь хатгалаад явахын аргагүй хүнд өвчлөөд

хэвтжээ. Тэд өөрөө элдэв арга гардсан ч тус гарсангүй. Оройд нь амьсгал хүчирдээд бие тэнхээ алдаад байдал муу болсонд, тэр тэндэхийн хэдэн монголыг дуудуулж ирээд “нэг тэмээ худалдаж өгөхтүн!” гээд бас энэ 300 адууг арван өдөр нүд болж хариулж өгөхийг захижээ. Дараа нь бас хамт найз нартаа: “намайг тэмээнд ачаад түргэн явцгаа, хэрэв зам зуур үхэж оддог юм болбол хүүрийг минь зам зуур хаяж орхилгүй, заавал Ховд дахь гэрт минь хүргэгтүн” гэж захижээ.

Дуудагдаж ирсэн монголчууд Хейит Эхүн Рүзины байдал муу байхыг үзээд: “шамдаад нэг тарган хонь алагтун” гэж алуулж орхиод, гурван дугтуй өвсөн эм буцалгаж бүгдийг нь уулгаад, хувцсаар нь ороогоод хэвтүүлж орхиод хонины шинэ шөлнөөс нэг гадар авч ирээд самарч самарч ам халдаггүй бараг болоход уулгаж, тэр шинэ алсан малын арьсанд ороогоод унтуулж орхижээ. Хейит Эхүн Рүзи маргааш үдэд сэрээд бие цогц нь хөнгөрч эдгээд хот будаа идээд гадаа гарчээ. Хейит Эхүн Рүзи эдгээд сайн болсоныг үзээд тарган лам үдийн хойно айлдаа харих болжээ. Хейит Эхүн Рүзи ламд маш талархаж, гар доорх хүмүүстээ: “ламд эмээл тохомтой сайн нэг морь унуулж явуулагтун” гэж захиад бас тэр ламд: “Хэрэв та үгүй болсон болбол би үхэж оддог билээ. Миний амийг та аварч хоцров. Би танд эмээл тохомтой нэг сайхан морь өгсүү, унаад харигтун” гэсэнд тэр лам: “Би чамд гуравхан дугтуй эм өгсөн билээ. Тиймээс гуравхан төгрөг өгөөд, морь авч болохгүй” гэжээ. Хейит Эхүн Рүзи: “Би өөрийн сайн дураас өгч байна. авахтун” гэсэнд тэр лам: “Тийм их юм авбал надад бузар болоод бурханы өмнө нүгэл болно, тиймээс авахгүй” гэжээ. Хейит Эхүн Рүзи “Тийм болбол зуун төгрөг мөнгө ав” гэж ламын өвөрт чихсэнд, тэр лам: “Гурван төгрөг авна би, илүү авбал ялтай болно” гэж эргүүлээд: “Гуравхан төгрөг авна би, илүү зоос ч авахгүй, дөхөм болбол намайг гэрт минь хүргүүлж өг” гэсэнд, Хейит Эхүн Рүзи эцэстээ гурван төгрөг өгч, өөрийн мориороо гэрт нь хүргүүлж өгчээ.

1949 онд Бүгд Найрамдах Дундад Ард Улс байгуулагдаад, Монгол улс, Дундад улс маш түргэнээр гадаад харилцааны харьцаа холбоо байгуулж, нийгэм журамт лагерийн хамгийн дотно ханийн нэг болсон билээ. Энэ чимээг сонссон Монгол улс дахь уйгарчууд маш их баярлаж, тэд бас Шинжаны урт удаан хугацааны дайн дажин зогсоод, Шинжанд ч Монгол улстай адил эв хамт нам удирдлага хийж байхыг сонсоод, удаан жилээс нааш хүсэн санаж байсан төрсөн нутагтаа харих гэсэн хүсэл эрмэлзлэл нь дахин бадарсан билээ. Тэдний олонх нь 20-30 жилээс нааш ямар нэг өдөр эх орондоо харина гэсэн хүсэл эрмэлзэлтэй учраас Монгол улсын харьяатан болсонгүй, мөн Дундад улсын харьяатнаараа байсаар байжээ.

Монгол улсад байсан уйгарчууд 1952 оноос эхлэн радиогоос Шинжаны ардын радиогийн нэвтрүүлгийг сонсож, Шинжаны эл газарт болж байх хувиралтад маш их баярлаж, зарим нь өөрийн нутгийнхаа шинэ чимээг олж сонсвол хонь алж гийч залдаг байв. Ялангуяа радиогоос Фатим, Курбан, Паша, Иша нарын дуулсан дууг сонсоод сэтгэл хөдөлж нүднээсээ нулимс асгаруулдаг байжээ. Ингээд тэдний төрсөн нутагтаа харина гэсэн хүсэл эрмэлзэл нь улам хүчтэй болсон байв.

1952 оны намар Ховд хотод байсан уйгарчууд хэдэн удаа цугларан ярилцаад зуу өнгөрүү хүний гар тавьсан “Дундад улсдаа харина” гэсэн өргөдөл бичгээ хотын дарга Лувсанбалданд өгчээ. Тэд ингээд хэд хэдэн удаа өргөдөл бичиг өргөсөнд засгийн газрын талаас: “Харина гэсэн өргөдлийг тань Төв хороонд явуулсан билээ, одоо болтол чимээ ирээгүй” гэж хариулжээ. 1954 оны эхээр Монгол улсын Төв хорооноос Ховд дахь уйгар айлд нэг байцаах дугуйлан явуулж, тэнд уйгарчуудтай нарийн нямбай ярилцаж, тэднээс: “юуны учирт харих гэж байх буй? Тус газрын засгийн ордон та нарыг

хазайлгасан уу? доромжилж монголтой адил эрх тэгш үзсэнгүй юү? Та нарыг гомдоосон газар байх уу?” гэх мэтийн байцаалт хийжээ. Уйгарчууд: “Бид монголын засгийн газарт маш талархана, зөвхөн төрсөн нутгаа санасан учирт харих өргөдөл бичсэн билээ” гэжээ. Энэ тухай Монгол улсын засгийн газрын холбогдолтой байгууллагаас уйгарчуудын Дундад улсаа харих гуйчлал хийсэн учир шалтгаан, тэдний харих зөвшөөрөл өгөх эсэх тухай дахин дахин ярилцжээ.

1954 оны намар Монгол улсын тэргүүлэгч Ю.Цэдэнбал ажил байцаагаад Ховд хотод ирж, уйгарчуудын айлд одоход, зуу өнгөрөх уйгар эрэгтэй эмэгтэй хамтдаа тэргүүлэгч Цэдэнбалд Дундад улсад харих гэсэн өргөдөл бичгээ өргөжээ. Тэргүүлэгч Цэдэнбал тэдний өргөдлийг хүлээж аваад, бас тэдэнд: “та нар Шинжанд харина гэж гуйчлал хийсэн нь зөв байна., Хүн төрөлхтөн өөрийн төрсөн нутгаа санах нь зүйтэй. Гэтэл Дундад улс чөлөөлөгдөн арай арван тавхан жил болов. Одоо ч гэсэн хүчир бэрхшээл нь шийдвэрлэгдээгүй. Монгол улс чөлөөлөгдөн 30 жил өнгөрүү болсон ч бас хүчир бэрхшээл нь шийдвэрлэгдээгүй байсаар. Та нар одоо Шинжанд удвал зовж зүдэх магад, одоо 10 жилийн дараа одоохул болно, тэр цагт би танай хүн бүрт 3000 төгрөг өгч, тусгай бичиг бичиж өгөөд, нисгэлээр Бээжинд хүргэж орхиле. Та нар одоо хөвгүүд хүүхэн, мал хараа хөдөлгөлгүй энд байлгаж байгаад, өөрөө одож нэг жил байж, эх улс төрөл саднаа үзээд ирэгтүн. Ирсний хойно нүүгээд явна гэвэл бид та нарыг замд тавьж явуулья. Та нарын хөвгүүд хүүхэн тань Монгол улсад төрж өссөн, Шинжаныг үзээгүй, тэнд одоод тэсч чадахгүй болбол гачигдалд учирч удах болно. Та нар Шинжанд одоод харьж ирэх хүртэл мал харыг чинь засгийн талаас хавсран харж байтугай.” гэжээ.

Энэ үгийг сонсоод уйгарчууд: “Энэ монголчууд биднийг хуурч байна. Биднийг хилээс гаргаж орхиод, гэр бүл хөвгүүд хүүхнийг минь авч хоцрох болж байна. Бид бүр хамтдаа нүүж явна, хөвгүүдээ төрөл садандаа үзүүлнэ” гэгцгээжээ.

1955 оны 3 сард тэргүүлэгч Цэдэнбал уйгарчуудын эх орондоо харих гэсэн эрэмшлийг зөвшөөрөөд, бас энэ бичгээ Дундад улсын засгийн газарт явуулсан тухай чимээ иржээ.

1955 оны 3 сард Дундад улсын засгийн газраас Монгол улсад байх Дундад улсын харьяатан уйгарчуудын төрсөн нутагтаа харихыг угтаж, харих гуйчлалыг зөвшөөрсөн тухай баяртай чимээ иржээ. Дагалдан Монгол улсын засгийн газраас тэднийг Дундад улсад хариулах тухай нарийн байршуулалт ч хүргээд ирэв.

Энэхүү байршуулалтад: “Уйгарчууд хэдэн хэсэгт хуваагдаж явна” гэжээ. Нэгдүгээр хэсэгт эрэгтэй эмэгтэй хоёулаа бүр Дундад улсаас ирж, одоо болтол Дундадын харьяатан гэдгээ хадгалж хоцорсон болохул гэр бүлтэйгээ бүр харьж болно. Тэдний харих зам нь Ховд-Улаанбаатар-Бээжин-Өрөмчөөр дамжин явна. Одооноос эхлээд хоёр сарын дотор гарах бэлтгэлээ хийж, хашаа хороо, мал хараа засгийн газарт эсгэж хувь хүнд ч худалдаж болдог тухай мэдэгдэл гаргажээ. Ингээд анх удаа явах завшаантай болсон хүмүүс баярлан бахдаж, завшаан хүртсэнгүй хүмүүс гуниран гутарч байв.

1955 оны 5 сарын 5-ны өдөр Уйгарчууд Ховд хотоос 24 өрх гэр бүлтэйгээ 10 газ машинд суугаад Улаанбаатарын зүг замд гарав. Дараах сэлгээнд хоцорсон уйгарчуудаас гадна, монгол, хасаг ах дүү нар ба засгийн газрын ажилтан нар мянга шахуу хүмүүс гарч биднийг үдэн мордуулав. Миний эцэг эх хоёр бүр Дундад улсаас одсон мөртөө бас Дундадын харьяатан гэдгээ хадгалсаар байсан болохоор миний гурван эгч бид нэг гэр бүл зургуулаа анх удаа төрсөн нутагтаа харих завшаантай болсон билээ.

Бид Ховд хотоос гараад долоон өдөр яваад нийслэл Улаанбаатарт хүрч ирэхэд, эндээ бас гурван өрх уйгар нийлжээ. Ингээд тэргүүн удаа Дундад улсад харьдаг

уйгарчууд 27 өрх 94 хүн болжээ. Тэд Улаанбаатарт наймаа хийсэн бөгөөд явах гарын гүйцэтгэлээ бүтээж, явах нисгэл хүлээжээ. Энэ хугацаанд Монгол улсын Гадаад Явдлын Яам болон Дундад улсын Монгол улс дахь элчин сайдын яамны талаас эдгээр эх нутагтаа харих болсон уйгарчуудад үдэшлэг хийж гийчилжээ.

Тэр цагийн нисгэл бүр бага болохоор зөвхөн 24 хүн багтдаг тул тэд дөрвөн хэсэгт хуваагдан явах болж, анх удаа нисгэлээр явагчид 1955 оны 6 сарын 28-ны өглөө Улаанбаатараас нисч, үдээс хойш Бээжингийн нисгэлийн буудалд буужээ. Манай гэр бүл ч энэхүү анх удаагийн харьсан хүмүүстэй хамт иржээ.

Монгол улсын засгийн газраас анх удаа Дундад улсад хариулах гэсэн төлөвлөгөөгөө Монгол улсад сууж байгаа дундад улсын элчийн яамаар дамжуулаад Дундад улсын гадаад явдлын яаманд мэдүүлээд, гадаад явдлын яам төв хороонд мэдүүлсэнд, уйгарчуудыг хүлээж аваад тохинуулах ажлыг төв хорооноос улсын үндэсний хэргийг хамаарах байгууллагаас даалгаж өгсөн бөгөөд Шинжан мужийн засгийн газар /тэр үед өөртөө засах орон байгуулагдаагүй/-т мэдүүлж: “та нар тусгайлан Бээжинд хүн явуулж харьж ирсэн хүмүүсийг хүлээн авч тохинуулаад, Шинжанд одсоны хойно, тэдний өөрийн шаардлагын ёсоор амьдралыг нь сайнаар байршуулагтун” гэж захижээ. Шинжан мужийн засгийн газраас 24 настай ажилтан Мухаммед Самсагаг Бээжинд явуулаад Монгол улсаас ирсэн уйгарчуудыг хүлээж авах үүргийг даалгажээ. Анх удаа улсдаа харьсан уйгарчуудыг Бээжинд ирсэн үед Мухаммед Самсага ирээгүй билээ. Улсдаа харьсан уйгарчуудыг улсын үндэсний хэрэг эрхлэх зөвлөлөөс нисгэлийн буудалд одож хүлээн авав. Тэр үед улсын үндэсний хэрэг эрхлэх зөвлөл Бээжингийн Дүн ши гэдэг газарт байсан билээ. Тэд албан гэрийнхээ ард байх нэг том хороог хөлсөлж аваад, аль нэг гэр бүлд нэг аман гэр хуваан өгчээ. Улсдаа харьсан уйгарчууд Бээжинд ирсний гурван өдрийн дараа Мухамед Самсага ч Өрөмчөөс Бээжинд хүрч иржээ. Улсын үндэсний хэрэг эрхлэх газраас мөн даруй хурал хийж, Монгол улсаас улсдаа харьсан уйгарчууд Бээжинд ирсэн өдрөөс эхлэн өөрийн нутагтаа одож байрших хүртлэх хэвтэх байр, идэх будаа, зам харилцаа, эмчид эмнүүлэх мэтийн зардлыг бүр засгийн газраас даах болж тогтжээ. Түүний хамт тэднийг Бээжин дэх зугаацлын газраар тойруулан наадуулжээ. Энэ хугацаанд Бээжинд бүх улсын ардын төлөөлөгчдын их хурал нээгдэж байв. Тухайн үед Шинжан мужийн засгийн газрын дэд дарга Сайфидин Айзези өөрийн бие нь яаруу болсон учраас Төв хорооны Шинжан муж дахь хуваарь тасгийн дэд дарга Сейдуллаа Сейфулалёвыг улсдаа харьж ирэгсдийг тохинуулахаар буудлын газарт явуулжээ. Тэр гэр бүхэнд орж, харьж ирэгсдийн гэр бүлтэй уулзаад, удирдагчдын мэндчилэлийг дамжуулж, харих үедээ Мухаммед Самсагад дэд дарга Сайфидин Айзезийн “улсдаа харьж ирсэн ах дүү нарыг амар мэнд Өрөмчид хүргэтүгэй” гэсэн зааврыг онцгойлон дамжуулжээ.

Гурван өдөрт Улаанбаатараас Бээжингийн нисгэлээр зөөсөөр байж, анхдугаар удаагийн улсдаа харих уйгарчуудыг арван хэдэн өдөр дотор Бээжинд авчирч буулгаад, улсын үндэсний хэрэг эрхлэх зөвлөлөөс улсдаа харьж ирсэн уйгарчуудыг тусгай суудлын машинд суулгаад Бээжингийн Тиан Тан цэцэрлэг, хааны ордон, амьтны хүрээлэн мэт газраар зугаацуулан наадуулав. Долдугаар сарын Бээжингийн уур амьсгал маш халуун үе болохоор настайчууд нь тэсч чадалгүй өвчлөөд, хэдэн настайчууд нь эмнэлэгт хэвтээд арай эдгэжээ. Ингээд тойрон үзэх болсон бусад үзэмжийн газар ч хоцорчээ. Долдугаар сарын эцсээр Бээжингээс гал тэргэнд суугаад Шинжан зүг замд гарч, Са Анд зургаан өдөр байж өдий төдий газрыг тойрон үзээд, 8-р сарын 9-нд гал тэргэнд суугаад Ланжоуд хүрч иржээ.

Тэр үед Төмөр зам Ланжоугаас бас өнгөрөөгүй байсан тул, Ланжоугаас Өрөмчийн хооронд нэвтрэх суудалтай ээлжийн тэрэг маш цөөхөн болохоор нутагтаа харигсад Ланжоуд нэг гараг саатжээ. Настайчууд халуунд чадалгүй дахин өвчлөв. Яг энэ үед Сайфидин Айзези бүх улсын ардын төлөөлөгчдийг дагуулаад Бээжингээс нисгэлээр Ланжоуд хүрээд ирэв. /тэр үед Бээжингээс ниссэн нисгэл Ши анд нэг, Ланжоуд нэг хоноод гуравдугаар өдөр нь Шинжанд ирдэг./ Мухамед Самсага улсдаа харьж ирэгсдээс хэдэн төлөөлөгчдийг дагуулаад Сайфидин Айзези хэвтсэн гэрт одож, нэг гарагаас нааш машин олдохгүй байх, настайчуудын өвчилж байх байдлаас мэдүүлэлт хийсэнд, Сайфидин Айзези бие нь өвчилсөн настайчуудыг төлөөлөгчидтэй хамт нисгэлээр аваад явах болж, Шинжаны Ланжоуд суух хэрэг эрхлэх газрын дарга нартай ярилцаж, америкийн цэргийн олзолж хоцорсон “тоох” тэмдэгтэй гурван том машинд тарсан одох барааг буулгаж хаяад, тэдгээр хүмүүсийг эд бараатай нь машинд суулгаад замд гарчээ. Ингээд Монгол улсаас нутагтаа харих болсон уйгарчууд 1955 оны 5 сарын 5-ны өдөр Монгол улсын Ховд хотоос замд гараад 8 сарын 20-ны өдөр, ондоогоор хэлбэл 109 өдөр аялаад мэнд амгалан Өрөмчид хүрээд иржээ.

Өрөмчид эдгээр улсдаа буцаж ирсэн уйгарчуудыг хүлээж авах ба өөрийнх нь нутагт буцуулах ажилд Шинжан мужийн үндэстний хэрэг эрхлэх зөвлөлөөс эзэн болж, Палтахун баяны асарын ард байсан мужийн үндэстний хэрэг эрхлэх зөвлөлийн нэг давхар буудлын газарт байршуулжээ.

Мужийн үндэстний хэрэг эрхлэх зөвлөлөөс тэднийг Өрөмчид хэдэн өдөр амруулан Өрөмч хотыг тойруулан үзүүлээд, нутаг дахь төрөл садантай нь харицаа холбоо хийлгүүлж, бас том хүмүүст нь нэг өдөр хоёр төгрөг, бага хүүхдэд нэг төгрөгийн зардал мөнгө тарааж өгчээ. Тэр үед Өрөмчид нэг грамм алтан арай 2,68 төгрөг байсан, нэг хүн өдөртөө гурван удаа будаа идсэн ч нэг төгрөгийг зараад барахгүй байжээ.

Тэдгээр өдрүүдэд бас Сайфидин Айзезиний байршуулалтын ёсоор Шинжан мужийн Катарчуудын товчооноос улсдаа буцаж ирсэн уйгарчуудын доторх ном бичигтэй хүмүүсийг данслаад, тэднийг Өрөмчид эсгээж, өөрийн одох гэсэн газар оронд нь ажилд байршуулах тогтоол гаргаж, Курлийн Абдурахман Сафут гэдэг хүн дунд зэргийн мэргэжлийн хүмүүжил хүртсэн болохоор Курлийн монгол сургуулийн багшаар ажилд байршуулж, баян Ибирен гэдэг хүний Тилла, Сар гэдэг хоёр охин нь монголоор уншаад, Ховд аймгийн уран сайхны бүлгэмд тоглогч болж байсан тул Курлийн уран сайхны бүлгэмийн тоглогчоор байршуулжээ. Хоёрдугаар удаа Алтайгаар монгол улсад орж ирсэн уйгарчуудын доторх Тюп Эхүн Рузийг Алтай хотын наймаа худалдааны хоршооны дэд дарга, Гафар гэдэг хүнийг аймгийн монгол сургуулийн багш, Бүсерей Бекрийг “Шинжаны өдрийн сонин”-ны монгол найруулах хэлтэст байршуулжээ.

Улсдаа харьж ирсэн уйгарчууд Өрөмчид нэг гараг байсны хойно тэднийг тус тусад нь өөрийн өөрийнх нь нутагт нь явуулсны хамт, тус газрын засгийн газарт тэднийг сайнаар байршуулахыг захив. Эдгээр улсдаа буцаж ирсэн уйгарчууд ерөнхийдөө Бэркүл, Турфан, Читай, Или, Курла, Куцагар, Ахасу, Атуш, Кашкар, Хотайн зэрэг газрын хүн байсан билээ.

Миний эцгийн уг нутаг нь Атушийн Китай болохоор 1955 оны 9-р сарын дунджаар засгийн газраас гаргаж өгсөн машинаар Өрөмчөөс замд гарч, 12 өдөр дээрээ Китайд хүрсэн билээ.

Монгол улсын засгийн газраас хоёрдугаар удаа улсдаа буцсан уйгарчуудыг Алтайн хилээр шууд Шинжанд оруулжээ. 1956 оны 9 сарын 28-ны өдөр Монгол улсын Ховд хотоос 50 өрх 357 хүн замд гарч, Алтай аймгийн Цэнгэл шианы /булган/ Такашкин

хилийн боомтоор Шинжанд оруулжээ. Эд нарын дотор 5 хятад хүн байж, эмэгтэй нь бүр монгол байлаа.

Эдгээр хүмүүс Монгол улсын засгийн газраас “хүн бүр нэг морь, нэг тэмээтэйгээр хилээс гарч болно” гэж зөвшөөрөл олж, үлдээсэн хашаа хороо, мал хараа монголын засгийн газарт буюу хувь хүнд худалдсан байжээ. Тэд авч явмаар ачаа бараагаа морь тэмээндээ ачаад хилээр орж иржээ. Гуравдугаар удаа Өлгий хотоос Дундад улсад буцсан 7 өрх бүр машинаар Алтай хотод иржээ. 1957 онд Улаанбаатар, Ховд хотоос Турсун дарга, Ягасун тоглогч гэдэг хүмүүс Читайгаар дамжаад улсдаа харьж ирсэн билээ.

Шинжаны Уйгарын Өөртөө Засах Орны засгийн газраас Турсун даргын Монгол улс дахь цол зэрэг тушаалыг мэдсэний хойно, түүнийг Лү Дү Фаны нүүрсний уурхайн дэд даргаар байршуулсан билээ. Гэтэл Турсун дарга Ягасун тоглогч Кашкарын Бесигиремд харьсан Итиб Эхүн, Хотайнд явсан Яхов Бай Ши Аны Мухамед Хошимак мэт хүмүүс 1958 онд Цэнгэлээр Монгол улсад ирээд харьсанд, Монгол улсын засгийн газар бас л халуунаар угтаж аваад байршуулжээ.

Монгол улсад хоцорсон уйгарчуудын нэг хэсэг нь 1962 онд Узбекистанд явж, бас нэг хэсэг нь 1998 оноос 2002 оны хооронд Казакстанд нүүж явжээ. Одоо Монгол улсад бас хэдэн зуун өрх уйгар үндэстэн амьдран сууж, тэд голдож Ховд, Улаанбаатар, Өлгий зэрэг хотуудад амьдран сууж байна.

Би 1991 оны 5-р сард төрөл саднаа хайгаад Монгол улсад одов. Энэ үед уйгарчууд Монгол улсаас яваад 36 жил болж харьцаа холбоо тасарсан билээ. Би бол анх удаа Монгол улсад төрөл саднаа хайгаад одсон уйгар болно. Намайг гурван өрх уйгар Улаанбаатарын гал тэргэний өртөөнд тосч, Улаанбаатараас Ховд хотод одсонд, 100 өнгөрүү хүн нислэгийн буудалд одож тосч авав. Тэдний олонх нь уйгарчууд билээ. Нагац минь намайг тэврээд нэлээд удаан уйлав. Ондoo хүмүүс ч намайг тэвэрч үнсэж байв. Гэтэл би тэднийг танидаггүй байсан, тэд намайг саначихсан биш, харин надад их улсынхаа уйгарчуудаа тэврээд үнсэж байна гэдэг төрөгдөл оров. Би одсоны маргааш нь нагац минь намайг ирэв гэж төрөл садан, айл хөрш нараа хань нөхөр нараа дуудаж, маш их гийчлэлгээ хийв. Миний нагацын Ховд голын хөвөө дэх уужим том хороо нь хүнээр дүүрч, том нэг хайсанд полоов хийж, бас нэг хайсанд дүүрэн мах чанаж, будаан ширээ дээр талх, хорхой боорцог, хуурсан бяслаг, шар тос тавигдаж, бас миний Өрөмчөөс авч очсон чихэр бурам, чихэрт боов зэрэг тавигдаж ирсэн зочид маш амтархан идэж байв.

Тэд надаас тасралтгүй энэ тэрийг асууж, эцэг /миний эцэг 1981 онд Борталд нас барсан/ ээж, гурван эгчийг минь байтал, тэдний хэдэн хөвгүүдийн амьдрал нь ямар байхыг асууж, бас Монгол улсаас нутагтаа харьсан уйгарчуудыг аль хотод байх, тэдний хөвгүүд нь ямар ажил хийж байхыг, Дундад улс дахь уйгарчуудын хүн амын тоо, утга соёл, зан заншил, шашин суртахууны эрх чөлөө мэт арвин олон юмыг асууж байв. Нэг барагт толгойдоо цагаан алчуур боосон хоёр хасаг эмгэн орж ирсэнд бүгдээрээ босоод ёслол мэндлэв. Тэд “гийч минь аль буй” гэж асуусанд нагац минь намайг үзүүлэв. Би ч өмнө нь очсонд тэд намайг сэлгээд сэлгээд элгэндээ шахан тэвэрч байгаад: “хөвгүүн минь... хөвгүүн минь” гэж үнсээд, үнэртээд: “Тохуган /миний ээж/-ны минь үнэр гарч байна.” гэж дахин дахин хэлж уйлалдав. Хожим нь тэдний ярианаас миний ээжтэй хамт нэг хороо дотор өссөн найз нөхөд нь байсныг мэдэв. Би ээжийнхээ нэрээр тэдэнд бэлэг гардуулав. Бас нэг өдөр нагацын гэрт хоёр монгол өвгөн орж ирсэнд миний нагац биеэрээ орчуулагч болж, тэднийг надад: “эд бол чиний эцгийн сайн найз болно” гэж танилцуулав. Тэд миний эцгийн нас барсныг сонсоод нүднээсээ нулимс асгаруулав. Тэд

надад чиний эцэг монгол хэл маш сайн хэлдэг, нөхөрсөг, хөдөлмөрсөг, хатуужилд чадамгай хүн байсан. Тэр Монгол улсад анх удаа гуа тарьж, монголчуудыг маш баярлуулсныг үлгэр болгон ярьж өгөв. Тэд бас уйгарчуудын хуушуур, бууз банш, сагс, шарсан бууз, татсан будаа мэтийн хоолыг магтан сайшааж: “Одоо тэр уйгарчууд яав? Юуны учирт явчихсан бэ? Уйгарчууд явснаас болж, тэдгээр амттай сайхан хоол будаа үгүй болов...” гэв.

Би нагацаасаа: “Одоо Монгол улсад байх уйгарчууд юунд хоолон гэр гаргаагүй вэ?” гэж асуусанд, нагац минь: “Урьдах уйгарчууд жинхэнэ уйгар байжээ. Тэд хаана очсон ч өөрийн зан дадхалаа хаядаггүй, мартдаггүй, ямар ч хүчир бэрхшээлийг дийлээд давж чаддаг байсан. Энэ газарт байх одоогийн уйгарчууд болбол гуравдугаар үеийн уйгар болно. Тэд болбол эрлийзжин хувирсан холимог уйгар юм. Тэд Орос, Монголын амьдралын зан дадгалд дасаад итгэл зориг буурсан байна. Тэд өдөр бүр дэлгүүрээс талх, хорхой боорцог, хайрсан боорцог, шар тос, водка зэргийг худалдан авч өдрийн гурван удаа идэж уудаг. Тэд сагс, татсан будаа, бууз банш хийж худалдана гэдгийг санаандаа авдаггүй, хийж ч чаддаггүй залхуу болсон байна” гэв.

Би Монгол улсад байсан 30 өдөр дотор Ховд хотоос гадна Өлгий, Завхан, Дархан, Улаанбаатар мэт хот балгасанд одож, миний эцэг байрласан, наймаа хийсэн, таримал тарьсан газар бүхнийг нэг нэгээр тойрон үзэв. Энэ явцад намайг маш гайхуулсан явдал болбол Монгол улсын ямар ч их бага хотод бүр бүрэн дэлгүүр музей байдаг. Аль нэг хотын музейд түүхэнд өнгөрсөн уйгар хаан төрийн уйгарчуудын түүх, утга соёл, зан дадхалыг тусгайлан байршуулжээ.

Улаанбаатрын их сургуулийн түүхийн салбарын музейд Орхон, Уйгар хааны тухай маш нарийн тодорхой танилцуулсан байв. Харихын өмнөх хэдэн өдөрт Орхон, Енисейн хөвөө дэх Уйгар хаант улсын чулуун хөшөөг ч гайхан үзэж амжив.

Би Монгол улсаас харих эцсийн өдрүүдэд Ховд хотод болсон нэг хэрэг одоо болтол нүдний минь өмнө үзэгдсээр. Нэг өдөр манай төрөл садан нар намайг миний аав ээж хоёр удаагийн аж төрж амьдарсан Намин дахь хуучин байрыг тойруулан үзүүлэхээр авч одов. Ховд голын хөвөөнд байх энэхүү тариалангийн талбай таван сар дотор өнгө бүрийн цэцэгт хучигдаж маш гоё сайхан харагдана. Энэ тав, зургаан мянган му тариалангийн талбайд одоо ч арван хэдэн өрх суурьшин сууж байлаа. Миний төрөл садан намайг дуудуулаад тэрхүү 50 жилийн өмнө миний эцэг атар хагалбарлан таримал тарихын төлөө Ховд голоос ус татан гаргахаар малтсан нэг километр урт усан бух сувгийг үзүүлэв.

Энэ газар одоо ч тэр бух сувгийн усыг уудаг байжээ. Хороо дотор миний эцгийн тарьсан бурга ба гуа тарьсан таригийн газрыг ч тойруулан үзүүлэв. Энэ таригийн газар одоо ч миний нагацын харьяанд байж, энд гуа, тариа тарьдаг. Тэд эцэст нь биднийг нэг том хашаанд дагуулж оров. Хашааны нэг буланд хоёр том тээрмийн чулуу байв. Энэ нь манай гурил татдаг тээрмийн чулуу ажээ. Энэ тариалангийн талбайд байсан хүмүүс бүр энд ирж гурил татаж авдаг байжээ. Манай угийн хуучин гэр нэгэнт нурсан тул нагац минь түүний хажууд ондоо гэр барьжээ. Нагац минь надад манай гэрийн хуучин буурийг үзүүлж байгаад: “*Чи энэ ертөнцөд ирж, хүйснийхээ цусыг асгасан газар энэ болно. Хөвгүүн минь чи 36 жилдээ уусан ус, унасан газартаа арай нэг ирэв....*” гэв. Энэ үед бидний эргэнд нэлээд олон хүн цугларсан байв. Тэд болбол манай хуучин айл хошоо хүмүүсийн хойт үес болно. Тэд нэг гэрт хонь алж хоол бэлтгэсэн тул бид хамтдаа маш баяр баясгалантайгаар хоол будаа идэв....

Бүгд Найрамдах Дундад Ард Улс байгуулагдсаны хойно Монгол улсаас Шинжанд харьж ирсэн Уйгарчууд өөрийн нутагтаа, өөр өөрийн ажлын байрандаа нийгэм журамт бүтээн байгуулалтад идэвхитэй оролцож, амар төвшин амьдрал өнгөрүүлж байна. Үүний хамт эл шатны засгийн газраас алсдаа буцаж ирэгсэдэд санаа орхин харгалзсаар ирэв. 1956 оноос “соёлын их хувьсгал” эхлэх хүртэл Курлагийн Ибирям Эхүн гэдэг хүн улсдаа буцагсдын төлөөлөгчөөр Бээжин хотод нэг жилд нэг удаа хуралд оддог байсан. Читайгаас Мариям, Борталаас Гафифар, Сайдулла Хасан Ягасун Гирем нар урт хугацаагаар Шинжаны Уйгарын Өөртөө Засах орны улсдаа буцсан харьяат нарын холбооны гишүүнээр ажиллаж буй. Үүнээс гадна бас хэдэн хүмүүс Өөртөө засах орон дахь Жоу аймаг, хот, шияны улсдаа буцсан харьяат нарын холбоонд ажиллаж, зарим нь багш, мэргэжилтэн, утга урлагчин, алдар нэртэй тоглогч болж, улс ба үндэстнийхээ төлөө хүч хөлсөө өргөж, гавьяа зүтгэл үзүүлсэн юм. Монгол улсаас харьж ирээд, Алтайн Цэнгэл шиянд байршсан Ханифа Агалам Эхүн маш хүчир бэрхшээлтэй /1960-1970-1980 он/ он жилүүдэд эл үндэстний өнчин хөвгүүдээс есөн хөвгүүнийг өөрийн төрсөн хөвгүүнтэйгээ адил асран өсгөж, үндэстний бүлгэмлийн үлгэр дууриал болсон бөгөөд нэн ялангуяа 2009 онд яруу алдартайгаар “Монгол даяар Дундадыг бишрүүлдэг 10 хувь хүний нэг”-ээр шагнагджээ.

Монгол улсаас улстаа харьж ирсэн уйгарчуудын нэг хэсэг үр хүүхэд нь одоо дунд зэргийн мэргэжлийн сургууль, их сургуулиудыг төгсөөд Шинжаны эл газар орны соёл сурган хүмүүжлийн эгнээ ба аж ахуй, ажил үйлсийн эгнээний идэвхитэн, нэгжийн дарга болж ажиллаад, Өөртөө Засах орны эл ажил үйлсийн хөгжилтөд маш их хувь нэмрээ үзүүлсээр байна.

Хамгийн эцэст, энэхүү мартагдашгүй түүхийн дурсгал ба үнэ цэнэтэй материалаар хангасан сайны оронд гарсан эцгээ дурсан талархаж, Шинжан мужийн засгийн газраас Бээжинд биднийг авахаар очоод, өдөр бүр өдрийн тэмдэглэл бичиж, тэрхүү эрхэм үнэтэй тэмдэглэлээ өгсөн Мухамед Самсага ахад, Монгол улсад 30 жил өдрийн тэмдэглэл бичиж үлдээсэн одоо таалал болсон Хэйит Эхүн Рүзи ахад онцгойлон ачлал мэдүүлж байна. Намайг бас арвин олон дурсамжаар хангасан Абдурахман Сафут ах, Гафифар ах, Бүсерей эгч нарт чин сэтгэлийн талархал мэдүүлж байнам.